



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
globe <http://rtcc.mrtd.gov.mn>
envelope info@rtcc.mrtd.gov.mn
phone +976 77244409


ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР


2018 оны 5-р сарын дугаар



“Төмөр замын хөгжил, салбарын ажилтнуудын нийгмийн асуудал” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулагдлаа.

Монгол Улсад төмөр замын салбар үүсэж хөгжсөний 80 жилийн ой энэ онд тохиож буй. Уг тэмдэглэлт баярыг угтан “Төмөр замын хөгжил, салбарын ажилтнуудын нийгмийн асуудал” сэдэвт зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын захирал Т.Ариунбаатар: “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагаа, хэтийн төлөв” сэдвээр илтгэл тавьсан юм. Тус зөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд, төмөр замын салбарын нийт 800 гаруй зочид төлөөлөгчид оролцсон юм.





“УБТЗ” ХНН-ийн Замын Үүд, Сайншанд, Чойр, БНХАУ-ын Хөх хотын төмөр замын Эрээн өртөөнүүдэд албан томилолтоор ажиллалаа

Төвийн захирал Т.Ариунбаатар, ХЗХБХ-ийн суурь бүтэц хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргил, ТМССХ-ийн мэдээлэл, статистик хариуцсан мэргэжилтэн Р.Мягмарсүрэн нар “УБТЗ” ХНН-ийн Замын-Үүд өртөөнд үүсээд байгаа ачааны вагоны хүрэлцээгүй байдал, замын хэмжээнд 4200 вагон ачаа хуримтлагдсан түүний дотор чингэлэг вагон ихэнх хувийг эзэлж байгаа шалтгаан нөхцөлийг судлан, шалгаж шийдвэрлэх арга хэмжээний талаар санал боловсруулах зорилгоор 2018 оны 5 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд “УБТЗ” ХНН-ийн Замын Үүд өртөө, Сайншанд өртөө, Чойр өртөө, БНХАУ-ын Хөх хотын төмөр замын Эрээн өртөөнд албан томилолтоор ажиллалаа.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг захиргааны ерөнхий хууль нийцүүлэн өөрчлөх ажлын хүрээнд:

“Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын төсөлд олони нийтээс санал авахаар Зам, тээврийн хөгжлийн яамны www.mrtd.gov.mn, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй мэдээлсэн. Мөн “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Болдтөмөр ерөө гол” ХХК, “Тээврийн дээд сургууль” зэрэг салбарын байгууллагуудаас санал авахаар 2018 оны 05 дугаар сарын 07-ны 117, 118, 119, 120 тус тус албан бичгээр хүргүүлж, ирсэн санал зөвлөмжийг судлан холбогдогдох зүйл заалтад агууллагаар нь тусгалаа.



“Хос зам” сургалтын төв нь Монгол улсын төмөр замын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж ажлын байр бий болгох, хөдөлмөрийн зах зээлд ажиллах үндэсний мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхийг эрхэм зорилгоо болгон ажилладаг.


“ГТХЗНТ” УТҮГ-ын харьяа “Хос зам” сургалтын төв нь 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан. Тус сургалтын төв нь Хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий газартай хамтран мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтыг хоёр дахь жилдээ зохион байгуулан ажиллаж байна. Мөн “Монголын төмөр зам” ТӨХК-тэй санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна. Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт”, “Зүүнбаян-Ханги”, “Эрдэнэт-Овоот, Зүүнбаян-Ханги-Мандал” чиглэлийн шинэ төмөр замын бүтээн байгуулалтад ажиллах мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтыг 2017 онд “Төмөр замын замчин” мэргэжлээр амжилттай зохион байгуулан суралцагч нарт мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээг олгосон. 2018 оны мэргэжлийн сургалтад зориулж анги танхимыг үзүүлэн самбар, зам, төмөр, бэхэлгээнүүд болон сургалтад шаардлагатай компьютер техник хангамжаар хангаж, суралцагчдын бүртгэлийг эхлүүлээ.




Суурь бүтцийн 2018 оны 5-р сарын хөдөлгөөний зурмаг тасалдлын тайлан

2018 оны 5-р сард нийт 163 тасалдал, 191,2 галт тэрэг цагийн барилт үүсч, 26,39 сая төгрөгний хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:



Тасалдлаас үүссэн хохирол, сая төг



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 9-н нэгж буюу 5,8%, 21,8-н цаг буюу 12,8%-иар, хохирлын хэмжээ 6,21 сая төгрөг буюу 30,77%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:





Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна


Төмөр замын болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын хоногийн болон сарын статистик мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн мэдээ
- Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ /өссөн дүнгээр/
- Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/
- Дамжин өнгөрөх ачааны мэдээ /чиглэл, зуучлагч, төрлөөр, өссөн дүнгээр/
- Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /чиглэл, зуучлагчаар, өссөн дүнгээр/
- Зорчигч тээвэрлэлтийн мэдээ
- Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын мэдээнүүд багтаж байна.



Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлүүдийн 5-р сарын дугааруудыг байршууллаа

2018 оны тавдугаар сард Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлийн 5-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэлээ.





БНХАУ-д “Ложистикийн хөгжил, удирдлага” сэдэвт сургалтад оролцлоо

БНХАУ-ын Худалдааны яам, Сужоугийн Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль хамтран хөгжиж буй орнуудын тээвэр, ложистикийн салбарын мэргэжилтнүүдэд зориулан зохион байгуулсан “Ложистикийн хөгжил, удирдлага” сэдэвт сургалтад төвийн мэргэжилтнүүд оролцлоо.





“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгууллаа



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Гэмт хэргийн тухай ойлголт”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах нь”, “Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвүүдээр сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгууллаа.



Төвийн албан хаагчид сургалт, мэдээллийн арга хэмжээнд тогтмол хамрагдаж байна

Төрийн албаны зөвлөлөөс Япон улсын дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам болон “РБА” олон улсын байгууллагатай хамтран удирдах албан тушаалтнуудад зориулсан “Бүтээн байгуулалт, барилгын салбарын менежмент болон удирдах албан тушаалтны үүрэг, хариуцлага” сэдэвт сургалт зохион байгуулагдлаа. Уг сургалтад төвийн ЗСХ-ийн дарга Н.Шинэбаяр, ХЗХБХ-ийн дарга М.Батмягмар, ТМССХ-ийн дарга Б.Энхжаргал, ахлах шинжээч Б.Батнасан нар оролцлоо. Мөн ЗТХЯ-наас зохион байгуулсан “Хөдөлмөрийн хуулийн нэмэлт, өөрчлөлт” сэдэвт сургалт, мэдээллийн арга хэмжээ, АТГ-аас зохион байгуулсан эрх зүй, хуулийн ажилтнуудад зориулсан сургалт болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Дахин үнэлгээ хийхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах, төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн цахимд хөрөнгийн бүртгэлийг хэрхэн бүртгүүлэх тухай” сургалтад төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа.





Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 80 мод тарилаа

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг энэ оны тавдугаар сарын 12-ны өдөр 9 дэх жилдээ зохион байгуулсан. Уг аяны хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, “УБТЗ” ХНН-ийн мэргэжилтнүүдтэй хамтран Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 80 ширхэг мод тарилаа.





 **8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс**

